

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дотоод хэргийн их сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/040/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Долгорсүрэн

Утас: 261885 Цахим хаяг: [dolgorsurenb@audit.gov.mn](mailto:dolgorsurenb@audit.gov.mn)

Ахлах аудитор: П.Амарсанаа

Утас: 261740 Цахим хаяг: [amarsanaap@audit.gov.mn](mailto:amarsanaap@audit.gov.mn)

Аудитор: Ж.Мөнхтуул

Утас: 261740 Цахим хаяг: [munkhtuulj@audit.gov.mn](mailto:munkhtuulj@audit.gov.mn)

Аудитор: Н.Нямсүрэн

Утас: 261740 Цахим хаяг: [nyamsurenn@audit.gov.mn](mailto:nyamsurenn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.05 № 07/652  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Дотоод хэргийн их сургуулийн 90 жилийн ой тайлант онд тохиосонтой холбогдон төгсөгчид болон хамтран ажиллагч байгууллагууд 9,756,908.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 241,344.3 мянган төгрөгийн бараа материал, нийт 9,998,252.5 мянган төгрөгийн биет хөрөнгө хандивласан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант оны төсвийн төслийг үндэслэлтэй тооцож төлөвлөдөггүйгээс тухайн жилийн зарцуулаагүй төсвийн үлдэгдлийг хэрэгцээ шаардлага үүсээгүй, үлдэгдэл хангалттай байхад нормын хувцас, хэрэгсэл авах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэмж батлуулан бараа, материал худалдан авч, нөөц үүсгэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Их сургуулийн үйл ажиллагааг нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, захиалагч агентлагийн эрэлд хэрэгцээнд нийцсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэх хүрээнд "Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг өөрчлөн зохион

байгуулах тухай” Засгийн газрын 2024 оны 122 дугаар тогтоолоор “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийг Дотоод хэргийн их сургуулийн харьяа болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,068,397,238.65</b>	<b>4,805,409,813.77</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>516,145,483.80</b>	<b>446,950,223.22</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>516,145,483.80</b>	<b>446,950,223.22</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>516,145,483.80</b>	<b>446,950,223.22</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>17,682,424.00</b>	<b>17,682,424.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>17,682,424.00</b>	<b>17,682,424.00</b>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	17,682,424.00	17,682,424.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>211,242,384.59</b>	<b>211,482,817.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	211,242,384.59	211,482,817.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,323,326,946.26</b>	<b>4,129,294,349.55</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,024,159,199.05</b>	<b>1,057,927,558.52</b>
35110	Тусгай зориулалттай материал	981,512,838.91	1,014,924,630.52
35130	Эм боох материал	42,646,360.14	43,002,928.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	34,554,600.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	802,980,628.35	1,263,697,666.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,496,187,118.86</b>	<b>1,773,114,525.03</b>
35410	Бичиг хэргийн материал	158,967,437.00	185,483,917.00
35420	Аж ахуйн материал	800,644,025.00	840,010,576.32
35430	Сэлбэг хэрэгсэл	57,368,900.00	56,019,469.00
35440	Түлш, шатах тослох материал	20,013,872.00	19,898,884.85
35450	Барилгын засварын материал	176,078,358.00	256,329,159.00
35460	Хүнсний материал	190,432,085.66	145,951,698.86
35470	Бусад хангамжийн материал	92,682,441.20	269,420,820.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>84,508,256,621.73</b>	<b>94,314,561,269.27</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>84,508,256,621.73</b>	<b>94,314,561,269.27</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>69,594,639,731.60</b>	<b>69,894,725,379.27</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,108,365,885.65	71,489,387,715.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,142,585,900.98)	(9,591,889,188.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,177,042,582.00	2,435,148,653.17
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,457,185,990.82)	(1,058,599,826.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,966,239,093.36	7,760,918,672.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,828,601,082.53)	(4,094,806,691.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,446,814,464.87	2,512,392,781.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,348,262,294.80)	(1,121,258,582.38)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	371,609,130.00	371,909,130.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(25,436,286.00)	(25,436,286.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	319,048,430.00	87,020,800.00
39217	Ном	1,007,591,700.85	1,129,938,200.85
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>14,913,616,890.13</b>	<b>24,419,835,890.00</b>
39301	Програм хангамж	165,812,045.50	486,225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(72,453,295.37)	(116,051,250.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>88,576,653,860.38</b>	<b>99,119,971,083.04</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,668,720.00</b>	<b>3,668,720.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,668,720.00</b>	<b>3,668,720.00</b>
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>3,668,720.00</b>	<b>3,668,720.00</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	3,668,720.00	3,668,720.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>88,572,985,140.38</b>	<b>99,116,302,363.04</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>88,572,985,140.38</b>	<b>99,116,302,363.04</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,588,860,843.91	5,588,860,843.91
51101	Өмч:- төрийн	5,588,860,843.91	5,588,860,843.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>61,525,915,598.73</b>	<b>72,155,567,610.29</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	61,525,915,598.73	61,612,250,387.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	10,543,317,222.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,458,208,697.74	21,371,873,908.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>88,576,653,860.38</b>	<b>99,119,971,083.04</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>22,188,802,679.26</b>	<b>45,829,586,625.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,843,117,484.80</b>	<b>13,987,014,019.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,368,841,455.80</b>	<b>13,234,244,466.78</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,272,553,222.00	12,845,925,577.36
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	951,297,960.00	1,543,016,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,106,015.00	5,900,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	10,457,835,544.58
120005	Түрээсийн орлого	9,329,220.00	-
120009	Бусад орлого	86,959,013.80	388,318,889.42
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>474,276,029.00</b>	<b>752,769,553.17</b>
122001	Хандив тусламж /дотоод/	474,276,029.00	752,769,553.17
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>20,345,685,194.46</b>	<b>31,842,572,606.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>18,909,982,300.00</b>	<b>30,836,013,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,909,982,300.00	30,836,013,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,435,702,894.46</b>	<b>1,006,559,406.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	484,238,094.46	312,353,098.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	951,464,800.00	694,206,308.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>23,384,907,789.84</b>	<b>35,254,007,403.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23,384,907,789.84</b>	<b>35,254,007,403.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,865,626,821.84</b>	<b>31,458,510,231.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>13,486,063,200.00</b>	<b>20,098,147,400.00</b>
210101	Үндсэн цалин	6,821,810,586.48	8,726,821,100.00
210102	Нэмэгдэл	5,637,983,600.00	9,148,062,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	579,935,200.00	1,803,231,549.25
210104	Урамшуулал	446,333,813.52	420,032,150.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,274,782,400.00</b>	<b>1,597,844,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	721,983,500.00	1,103,483,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	85,890,100.00	125,203,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	65,202,200.00	4,790,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,550,400.00	4,790,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	384,156,200.00	359,577,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>827,817,200.00</b>	<b>962,082,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	393,375,974.44	428,452,100.00
210302	Түлш, халаалт	324,940,807.34	399,142,600.00
210303	Цэвэр, бохир ус	109,500,418.22	134,487,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>438,459,843.04</b>	<b>462,448,277.29</b>
210401	Бичиг хэрэг	99,257,645.60	171,629,870.00
210402	Тээвэр, шатахуун	101,583,968.00	112,029,492.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,788,700.00	21,211,600.00
210404	Ном, хэвлэл	-	8,060,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,042,691.00	46,251,208.40
210408	Бараа материал акталсны зардал	147,786,838.44	103,266,006.89
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,850,357,445.50</b>	<b>2,729,277,428.28</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,177,503.69	48,214,678.14
210502	Хоол, хүнс	907,960,087.81	1,168,832,187.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	902,219,854.00	1,512,230,562.35
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>170,094,643.00</b>	<b>399,394,850.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	243,800.00
210604	Урсгал засвар	170,094,643.00	399,151,050.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,795,000.00</b>	<b>36,449,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,439,000.00	36,449,200.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	356,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>234,327,739.91</b>	<b>773,085,394.69</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,615,248.40	695,309,047.10
210803	Даатгалын үйлчилгээ	25,166,191.51	37,738,567.59
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,608,300.00	1,577,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	484,700.00	475,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,453,300.00	37,984,580.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,576,929,350.39</b>	<b>4,399,780,780.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,360,235.00	395,205,805.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,331,552.86	767,200,928.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,123,237,562.53	3,237,374,047.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,519,280,968.00</b>	<b>3,795,497,172.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,519,280,968.00</b>	<b>3,795,497,172.20</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,857,500.00	25,474,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,360,245,916.00	3,023,071,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	144,177,552.00	746,951,772.20
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(1,196,105,110.58)</b>	<b>10,575,579,222.66</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>399,695,395.00</b>	<b>32,262,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	36,600.00	4,400,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	229,420,500.00	10,596,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(399,695,395.00)</b>	<b>(32,262,000.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(1,595,800,505.58)</b>	<b>10,543,317,222.66</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>21,453,046,123.26</b>	<b>33,779,807,495.42</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,104,057,008.80</b>	<b>1,940,334,889.42</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,104,057,008.80</b>	<b>1,940,334,889.42</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,007,768,775.00	1,548,916,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	951,662,760.00	1,543,016,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,106,015.00	5,900,000.00
120005	Түрээсийн орлого	9,329,220.00	-
120009	Бусад орлого	86,959,013.80	391,418,889.42
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>20,348,989,114.46</b>	<b>31,839,472,606.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>18,909,982,300.00</b>	<b>30,836,013,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,909,982,300.00	30,836,013,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,439,006,814.46</b>	<b>1,003,459,406.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	484,238,094.46	337,944,506.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	951,464,800.00	665,514,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>19,907,867,567.46</b>	<b>32,532,377,861.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,907,867,567.46</b>	<b>32,532,377,861.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18,241,424,372.46</b>	<b>28,796,178,361.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>13,486,063,200.00</b>	<b>20,098,147,400.00</b>
210101	Үндсэн цалин	6,821,810,586.48	8,726,821,100.00
210102	Нэмэгдэл	5,637,983,600.00	9,148,062,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	579,935,200.00	1,090,658,600.00
210104	Урамшуулал	446,333,813.52	1,132,605,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,274,782,400.00</b>	<b>1,597,844,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	721,983,500.00	1,103,483,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	85,890,100.00	125,203,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	65,202,200.00	4,790,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,550,400.00	4,790,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	384,156,200.00	359,577,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>827,817,200.00</b>	<b>962,082,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	393,375,974.44	428,452,100.00
210302	Түлш, халаалт	324,940,807.34	399,142,600.00
210303	Цэвэр, бохир ус	109,500,418.22	134,487,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>211,388,150.00</b>	<b>329,304,250.00</b>
210401	Бичиг хэрэг	41,887,400.00	95,430,600.00
210402	Тээвэр, шатахуун	64,072,100.00	104,808,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,019,700.00	21,211,600.00
210404	Ном, хэвлэл	-	8,653,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,408,950.00	99,200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,524,045,040.00</b>	<b>3,123,168,654.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,486,900.00	27,945,054.00
210502	Хоол, хүнс	892,128,940.00	1,123,135,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	611,429,200.00	1,972,087,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>138,463,520.00</b>	<b>503,502,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,862,200.00
210604	Урсгал засвар	138,463,520.00	498,639,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,439,000.00</b>	<b>36,449,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,439,000.00	36,449,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>244,991,110.00</b>	<b>681,576,001.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,137,410.00	612,758,100.00

210803	Даатгалын үйлчилгээ	31,919,500.00	37,979,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,608,300.00	1,577,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	484,700.00	475,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,841,200.00	28,785,701.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>527,434,752.46</b>	<b>1,464,103,856.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,162,810.00	400,099,806.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	516,271,942.46	1,064,004,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,666,443,195.00</b>	<b>3,736,199,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,496,204,900.00</b>	<b>3,718,933,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,857,500.00	25,474,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,366,864,700.00	3,023,071,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114,482,700.00	670,388,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>170,238,295.00</b>	<b>17,266,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	170,218,295.00	17,266,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,545,178,555.80</b>	<b>1,247,429,634.42</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,049,033,072.00</b>	<b>1,316,624,895.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,049,033,072.00</b>	<b>1,316,624,895.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,049,033,072.00</b>	<b>1,316,624,895.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,049,033,072.00	1,316,624,895.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,049,033,072.00)</b>	<b>(1,316,624,895.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>496,145,483.80</b>	<b>(69,195,260.58)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>20,000,000.00</b>	<b>516,145,483.80</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>516,145,483.80</b>	<b>446,950,223.22</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,588,860,843.91</b>	<b>21,616,522,655.64</b>	<b>42,180,309,522.32</b>	<b>69,385,693,021.87</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	42,180,309,522.32	69,385,693,021.87
Тайлант үеийн үр дүн	-	-	24,124,234,161.06	24,124,234,161.06
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,588,860,843.91</b>	<b>21,458,208,697.74</b>	<b>61,525,915,598.73</b>	<b>88,572,985,140.38</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	86,334,788.90	86,334,788.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	21,458,208,697.74	61,612,250,387.63	88,659,319,929.28
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(86,334,788.90)	-	(86,334,788.90)
Тайлант үеийн үр дүн	-	-	10,543,317,222.66	10,543,317,222.66
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,588,860,843.91</b>	<b>21,371,873,908.84</b>	<b>72,155,567,610.29</b>	<b>99,116,302,363.04</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,367,663,200.00</b>	<b>32,367,663,200.00</b>	-	<b>100.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>32,367,663,200.00</b>	<b>32,367,663,200.00</b>	-	<b>100.0</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	28,682,648,700.00	28,682,648,700.00	-	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,098,147,400.00	20,098,147,400.00	-	100.0
210101	Үндсэн цалин	8,726,821,100.00	8,726,821,100.00		100.0
210102	Нэмэгдэл	9,148,062,600.00	9,148,062,600.00	-	100.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	1,090,658,600.00	1,090,658,600.00	-	100.0
210104	Урамшуулал	1,132,605,100.00	1,132,605,100.00	-	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,597,844,900.00</b>	<b>1,597,844,900.00</b>	-	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,103,483,100.00	1,103,483,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	125,203,000.00	125,203,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	4,790,600.00	4,790,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,790,600.00	4,790,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	359,577,600.00	359,577,600.00		100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>962,082,000.00</b>	<b>962,082,000.00</b>	-	<b>100.0</b>
210301	Гэрэл цахилгаан	428,452,100.00	428,452,100.00		100.0
210302	Түлш, халаалт	399,142,600.00	399,142,600.00		100.0
210303	Цэвэр, бохир ус	134,487,300.00	134,487,300.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>380,283,200.00</b>	<b>380,283,200.00</b>	-	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	95,430,600.00	95,430,600.00	-	100.0
210402	Тээвэр (шатахуун)	104,808,700.00	104,808,700.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	21,211,600.00	21,211,600.00	-	100.0
210404	Ном, хэвлэл	57,152,500.00	57,152,500.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	101,679,800.00	101,679,800.00	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,140,463,700.00</b>	<b>3,140,463,700.00</b>	-	<b>100.0</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	45,240,100.00	45,240,100.00	-	100.0
210502	Хоол, хүнс	1,123,135,800.00	1,123,135,800.00	-	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,972,087,800.00	1,972,087,800.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>602,104,200.00</b>	<b>602,104,200.00</b>	-	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	148,238,700.00	148,238,700.00	-	100.0
210604	Урсгал засвар	453,865,500.00	453,865,500.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>36,449,200.00</b>	<b>36,449,200.00</b>	-	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	36,449,200.00	36,449,200.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>690,540,000.00</b>	<b>690,540,000.00</b>	-	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	620,243,100.00	620,243,100.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	37,979,000.00	37,979,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,577,700.00	1,577,700.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	475,500.00	475,500.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	30,264,700.00	30,264,700.00	-	100.0
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,174,734,100.00</b>	<b>1,174,734,100.00</b>	-	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,317,900.00	2,317,900.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,172,416,200.00	1,172,416,200.00	-	100.0
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,685,014,500.00</b>	<b>3,685,014,500.00</b>	-	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,685,014,500.00</b>	<b>3,685,014,500.00</b>	-	<b>100.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	14,575,200.00	14,575,200.00	-	100.0

213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,023,071,200.00	3,023,071,200.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	647,368,100.00	647,368,100.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>32,367,663,200.00</b>	<b>32,367,663,200.00</b>	-	<b>100.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>30,836,013,200.00</b>	<b>30,818,747,200.00</b>	<b>17,266,000.00</b>	<b>99.9</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	30,836,013,200.00	30,818,747,200.00	17,266,000.00	99.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,531,650,000.00</b>	<b>1,548,916,000.00</b>	<b>(17,266,000.00)</b>	<b>101.1</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,525,750,000.00	1,543,016,000.00	(17,266,000.00)	101.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,900,000.00	5,900,000.00	-	100.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	570	542	28	95.1
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	509	484	25	95.1
620003	Үйлчлэх ажилтан	57	54	3	94.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,003,459,406.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>784,141,906.00</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	-	784,141,906.00
2106	Эд хогшил худалдан авах	-	440,197,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	429,097,400.00
210602	Тавилга	-	11,100,000.00
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>343,944,506.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	343,944,506.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>219,317,500.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	219,317,500.00
222001	Тоног төхөөрөмж	-	219,317,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>1,003,459,406.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,003,459,406.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	309,253,098.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	694,206,308.00

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 56,992.4 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар 843.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 56,149.4 мянган төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт
1	Сургуулийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 24,049,662.1 мянган төгрөгийн 5 газар байгаагаас Төв аймгийн Эрдэнэ сумын Ар жанчивлан дахь сургалтын баазын зориулалттай, 200,000.0 мянган төгрөгийн өртөгтэй, 10 га газрыг Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/330 дугаар захирамжаар газрын эзэмших эрхийг хүчингүй болгосон. Тус сумын Засаг даргад удаа дараа албан бичиг хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл шийдвэр гаргаж өгөөгүй байна. Аудитын явцад эд хөрөнгийн тооллого хийж, тус газар дээр очиход эргэн тойронд нь хашаа барьсан байдалтай байгаагаас харахад тус газрыг давхар эзэмшүүлсэн байх эрсдэлтэй байгаа тул сургуулийн удирдлага газрын хадгалалт хамгаалалт, ашиглалтад бүртгэлээр тавих хяналтаа сайжруулах шаардлагатай байна.	1	-			1	-		
2	Дотоод хэргийн их сургууль тайлант оны эцэст бараа, бүтээгдэхүүний үлдэгдэл хангалттай байхад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэмж батлуулан 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нэр бүхий 2 компаниас 296,675,000.00 төгрөгийн хэрэгцээнээс илүү, шаардлагагүй нормын хувцас, зөөлөн эдлэлийг худалдан авч нөөцөлсөн байна.	1		1					
3	Тайлант онд хувь хүнд олгосон орлогоос суутгасан 843,024.00 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй байна.	1	843.0	1	843.0				
4	Сургууль хөгжүүлэх санд төвлөрсөн 3,100.0 мянган төгрөгийн хандивыг зарцуулах эрх үүсээгүй байхад зарцуулсан байна.	1	3,100.0			1	3,100.0		
5	"Катар улсын Доха хотод албан томилолтоор ажиллуулах тухай" Хууль зүй дотоод хэргийн сайдын 2024 оны А/04 дүгээр тушаал, ДХИС-ийн захирлын 2024 оны А/09 дүгээр тушаалыг үндэслэн 13,849.4 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг зардлын ангилал, зориулалт зөрчин бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлсэн байна.	1	13,849.4			1	13,849.4		
6	ДХИС-ийн 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор баталсан төсөвгүй байхад Туушин зочид буудал ХХК-тай 200 хүн хүлээн авах арга хэмжээг зохион байгуулах 49,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 39,200.0 мянган төгрөгийн зардлыг хоол, хүнсний зардлаас санхүүжүүлсэн байна.	1	39,200.0			1	39,200.0		
7	Тайлант онд сонсогчдын сургалтын төлбөрт 1,543,016.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс 734,612.7 мянган төгрөгийн орлогын цахим төлбөрийн баримтыг шивж олгоогүй байна.	1	-			1	-		
<b>НИЙТ</b>		<b>7</b>	<b>56,992.4</b>	<b>2</b>	<b>843.0</b>	<b>5</b>	<b>56,149.4</b>	<b>-</b>	<b>-</b>